

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-12
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	6-8
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	8-9
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах удирдамжийг батлах тухай/	9
4.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	9-13

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит
чуулганы Нийгмийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 03 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, С.Ганбаатар, Б.Саранчимэг, Ц.Идэрбат;
Чөлөөтэй: Б.Баярсайхан;
Тасалсан: Ц.Мөнх-Оргил, С.Одонтуяа.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Анужин тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга П.Анужин хариулж, тайлбар хийв.

П.Анужин: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Анужин тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, М.Оюунчимэг, Б.Жаргалмаа нар орж ажиллахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах удирдамжийг батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Байнгын хорооны дарга П.Анужин танилцуулав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

П.Анужин: “Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах удирдамжийг батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 10 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр, Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, бригадын генерал Д.Ганхуяг, мөн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа Ч.Гандирваа, Хуулийн хэлтсийн дарга Г.Энхболд, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал С.Ганбямба, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын

бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн ”Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон” гэсний дараа “амаржсаны,” гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга П.Анужин, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал Г.Сайханбаяр нар хариулж, тайлбар хийв.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	1
Бүгд:	10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	1
Бүгд:	10

90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4, 5, 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

П.Анужин: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 1
Бүгд: 10
90.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 20 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 58.8 хувийн ирцтэйгээр 10 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Үндсэн
хууль” танхим 10 цаг 03 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

П.Анужин: Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.9 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг танилцуулъя.

Бейсен гишүүн хүрэлцэн ирсэн байна, Булгантуяа сайд ирсэн байна, Жаргалмаа гишүүн ирсэн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирсэн байна, Сарангэрэл гишүүн ирсэн байна, Туваан гишүүн хүрэлцэн ирсэн байна. Чинбүрэн гишүүн ирсэн байна, Чинзориг сайд ирсэн байна, Идэрбат гишүүн ирээгүй байна тиймээ чөлөөтэй байгаа юм байна. Нарын гишүүд хуралдаа хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Байнгын хорооны тогтоолын төслийн цаглавар батлах тухай асуудлыг эхлээд хэлэлцэнэ.

Түүний дараагаар Байнгын хорооны тогтоолын төсөл Хүүхэд хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулна.

Дараа нь Байнгын хорооны тогтоолын төсөл Нийгмийн бодлогын

байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийг хэсгийн ажиллах удирдамжийг батлах тухай,

Дөрөвдүгээрт нь Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газар 2022 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явагдана.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Байнгын хорооны 11 сарын цаглавар.

Даваажанцаны Сарангэрэл гишүүн асуулт асууя.

Д.Сарангэрэл: Та бүхэндээ өглөөний мэнд хүргэе.

Өчигдөр Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийн ажлын дэд хэсэг хуралдаад хуулийнхаа томъёолол дээр бас бид нар нэлээн сайн ажилласан байгаа тэгэхдээ дахиад цаашид ажиллах шаардлагатай. Би ажлын хэсэг албан ёсоор байнгын хорооноос байгуулагдсан уу? Тогтоол шийдвэр гарсан уу? Хаана байна. Тэгээд ажлын хэсгийн гишүүд нь хэн хэн юм, ажлын үндсэн гишүүд. Манай гишүүдээс хэн хэн орсон. Жаргалмаа өөр.

П.Анужин: Цоогий зөвлөх өө ажлын хэсэг байгуулсан тухай тогтоолыг, удирдамжийг аваад ирээрэй.

Д.Сарангэрэл: Би ажлын хэсгийн ахлагчийн хувьд тогтоолоо гар дээрээ аваагүй, ажлын үндсэн хэсэгтэйгээ ажиллаж чадахгүй байгаа байхгүй юу. Тэгээд би бүүр гайхаад энэ ер нь албан ёсны ийм ийм шийдвэр гарсан юм уу, үгүй юм уу гээд өөрөө ч мэдэхээ больчихоод тэгээд асууж байна.

П.Анужин: Баярлалаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор өөр саналтай гишүүд байна уу?

Өөр саналтай гишүүд байхгүй бол хэлэлцэх асуудалдаа оръё.

2023 оны 11 дүгээр сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглаврыг батална. Та бүхэнд цаглаврын төслийг тараасан байгаа.

Цаглавартай холбогдуулан асуулт асууж санал хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна. Байна уу? Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна?

Д.Сарангэрэл: Анужсин дарга цаглавараа харин танилцуулчихвал яасан юм?

П.Анужсин: Цаглаврыг Сарангэрэл гишүүн нийт Байнгын хорооныхоо гишүүдэд цаглаврынхаа агуулгыг танилцуулах санал гаргасан учраас саналын дагуу та бүхэндээ 11 сард хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төсөл Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Эдгээр хуулийг ажлын дэд хэсэг, ажлын хэсэг байгуулагдсан байгаа. Энэ цаглаварт тусгагдсан байна.

Түүний дараа Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл мөн хэлэлцэгдэнэ. Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа.

Түүний дараа Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газраас 2023 оны 3 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт

өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байгаа. Эдгээр асуудал 11 дүгээр сарын Нийгмийн бодлогын байнгын хорооны цаглавар тусгагдсан байна гишүүдээ.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн цаглавартай холбогдуулж асуулт асууна.

Ж.Чинбүрэн: Өглөөний мэнд.

Байнгын хорооны даргаас нэг ийм зүйл асуух гээд бид нэг чухал хуулийн төсөл Их Хуралд өргөн баригдаад Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих тухай хуулийн төсөл, үүний ажлыг би өөрөө ахалж байгаа. Бид бас сая БНСУ-д ажлын хэсгээрээ очиж бас энэ хууль баталсан оронд хэрэгжилтийнх нь талаар, бас мэдээлэл, нөхцөл байдал, сайн сул талуудыг нь бас судлаад яваад ирлээ. Тэгээд ер нь ингээд нэлээн тийм итгэл үнэмшил их сайн төрлөө. Ер нь энэ гол асуудал бол энэ ажлын байр байрыг нэмэгдүүлж, эдийн засагт том нэмэлт өсөлт авчирдаг гэдгийг нь ерөөсөө Солонгосын бүх шатын хууль хэрэгжүүлж байгаа байгууллагууд хэлж байна. Тэгээд бид бас энэ хуулиа бас цааши нь явуулах тал дээр нэлээн эрчимтэй ажиллала гэсэн төлөвлөгөөтэй байгаа.

Тэгэхлээр энэ дээр цаглаварт ороогүй байгаа учраас энийг бас анхааралдаа авч өгнө үү энийг оруулж өгнө үү гэж.

П.Анужсин: Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн бас чухал хуулийн талаар санал хэллээ. Даваажанцангийн Сарангэрэл нарын эмэгтэй гишүүдийн өргөн барьсан энэ бол маш чухал хуулийн төсөл байгаа.

Чинбүрэн гишүүн маань бас ахалж тодорхой бас бодитой ажлуудыг хийж хуулийн судалгаагаа маш сайн явуулж

байна гэж харж байгаа. Тийм учраас 11 сарын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглаварт уг хуулийн төслийг тусгаж өгнө үү гэж байна. Манай ажлын хэсэг анхаараад цаглавартаа тусгаад өгөөрэй.

11 сарын цаглавартай холбоотойгоор өөр асуулт асууж үг хэлэх гишүүд байхгүй бол. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн үг хэлье. Зөвхөн нөгөө цаглавар маань бид нарын Байнгын хороогоор хэлэлцэх хууль тогтоомжтой холбоотой л асуудал юм байна лээ. Тийм аанхан тийм зөвхөн хууль тогтоомжтой холбоотой асуудлууд байгаа. Даваажанцангийн Сарангэрэл нарын гишүүдийн өргөн барьсан саяын Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хуулийн төслөө цаглавартаа шингээгээд баталъя гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ.

Бейсен гишүүн дарсан боловч төхөөрөмж ажиллаагүй учраас Бейсен гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглэж үлдээнэ үү. 70 хувиар уг санал дэмжигдлээ. Баярлалаа гишүүдээ.

10.12 цагт

Хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд оръё оо.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Та бүхэнд тогтоолын төслийг танилцуулсан байгаа. Тогтоолын төслийг та бүхэндээ уншиж танилцуулъя.

Ажлын хэсэг байгуулах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь

хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа, Адъяасүрэн, Анужин, Баярсайхан, Булгантуяа, Жаргалмаа, Мөнхцэцэг, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Оюунчимэг, Өнөрболор, Сарангэрэл, Саранчимэг, Ундррам нарын гишүүдээс 2021 оны 3 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч Ц.Идэрбат Улсын Их Хурлын гишүүн. Ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй гишүүдийн нэрсийг авъя. Тийм бид нар эмэгтэй гишүүд нөгөө өөрсдөө хууль санаачилсан учраас тийм өөрсдөө энэ хуулийг ахлах боломжгүй байгаа. Тийм учраас Идэрбат гишүүнээр ахлагчаар томилж байна. Ажлын хэсэгт орох гишүүд нэрсээ өгье. Ажлын хэсгийн гишүүдэд ажлын хэсгийн гишүүдэд Баярсайхан гишүүн, Жаргалмаа гишүүн, Анужин гишүүн, Бейсен гишүүн, Оюунчимэг нарын гишүүд ажлын хэсэгт орж байна.

Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр холбогдох байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэг Ц.Идэрбатад зөвшөөрсүгэй. Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга Анужин гэсэн тогтоол.

Гишүүдээ Байнгын хорооны хурал явагдаж байна. Саяын тогтоол ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг

байгуулах тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүдээ.

Санал хураалт.

70 хувиар уг тогтоолын төсөл дэмжигдлээ.

Гишүүдээ хэлэлцэх асуудлынхаа дараагийн асуудалд орё.

10.15 цагт

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 8.3-д заасны дагуу Байнгын хорооны тогтоолоор баталдаг.

Та бүхэнд тогтоолын төсөл болон удирдамжийн төслийг тараасан байгаа. Тогтоолын төсөл болон удирдамж дээр саналтай гишүүд байна уу гишүүдээ?

Удирдамж байнгын хорооны. Байгаа юу? Өгчихсөн байгаа тиймээ? Саналтай гишүүд байхгүй байна.

2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн ажиллах удирдамжийг Байнгын хорооны тогтоолоор баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүдээ.

Санал хураалт.

70 хувиар уг төсөл дэмжигдлээ.

Хэлэлцэх асуудлынхаа сүүлийн асуудалд орё гишүүдээ.

10.17 цагт

Засгийн газраас 2022 оны 3 дугаар сарын 4-ний өдөр өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэндээ танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Гүрсэдийн Сайханбаяр Батлан хамгаалахын сайд, дэслэгч генерал, Сүнрэвийн Ганбямба ЗХЖШ-ын дарга хошууч генерал, Дагвадоржийн Ганхуяг Батлан хамгаала яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал, Чулуунборын Гандирваа Батлан хамгалаах яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга хурандаа, Гурбадамын Энхболд Батлан хамгаалах яамны Хуулийн хэлтсийн дарга хуулийн зөвлөх, Баасанжаргалын Батжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгаалын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Цэнд-Аюушийн Ганцэцэг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлого хэрэгжилт, судалгааны газрын дарга.

Ганаа дарга 2 номерын микрофон руу суучхаарай. Асуулт байгаа учраас. Ажлын хэсгийг та бүхэндээ танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцүүлнэ. Гишүүд хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Өөр саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүн алга байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал байна. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулж, сая авчихлаа.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн зарчмын зөрүүтэй санал 1 дүгээр зүйлтэй холбоотой гаргасан байгаа.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан Оюунчимэг гишүүн маань өөрөө байгаа. Гишүүд тодруулж асуулт асуухыг хүсвэл Оюунчимэг гишүүн хариулна.

Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэндээ уншиж танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Эмэгтэй цэргийн алба хаагчийн жирэмсний болон" гэсний дараа "амаржсаны," гэж нэмж, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 17¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"5.Цэргийн алба хаагч эмэгтэйн энэ хуулийн 17¹ дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацааны төлбөл зохих эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон сар бүр улсын төсвөөс хариуцан төлөх ба шимтгэлийг тухайн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлнэ."

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг.

Санал хураалт явуулъя гишүүдээ.

Зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт. Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

П.Анужин: Та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Нийгмийн даатгалын багц хууль яг хэлэлцэгдэж эхэлж байх тэр цаг мөчид би бас энэ талаар тодруулж байсан юм.

Цэргийн алба хаагч эмэгтэй гээд тэгчихээрээ яг цэргийн албанд мөрдөс зүүсэн эмэгтэй хамаарагдаад байгаа. Гэтэл цэргийн албанд жишээ нь хил дээр алба хааж байгаа хилчин дайчдын ар гэрийнхэн, гэр бүлийн эмэгтэйчүүд гэсэн үг тиймээ гэр бүл. Өөрөөр хэлэх юм бол тэд нар эр нөхрөө дагаад л хил дээр яваа гэсэн үг. Тэгээд нөхөр хаана томилогдоно уу нөхрийг дагаж хил дамнаж хил

дамжиж явсаар байгаад, застав дамжиж явсаар байгаад тэд нар тогтсон ажил төрөлгүй ийм байдаг. Өөрөөр хэлэх юм нийгмийн даатгал тогтмол төлж чаддаггүй. Тэгээд би яг тэр хуулийн төсөл ярьж байхад энэ эмэгтэйчүүдийг нийгмийн даатгалд хамруулдаг байх, төр хариуцдаг байх эсвэл нөхрөө дагаад эрт тэтгэвэрт гарчихдаг. Тэтгэвэр тогтоолгох нас нь хүрээгүй байдаг. Тэгээд энэ асуудал дээр ер нь зохицуулалт хийж болох уу, үгүй юү гэдэг зүйл асууж байсан юм. Тэгээд энэ Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль дээр бас өөрчлөлт ороход бас энэ асуудал уг нь орж ирэх болов уу гэж бодож байсан. Өөрөөр хэлэх юм бол цэргийн алба хааж байгаа эрчүүдийн эхнэрүүд гэсэн үг.

Гэр бүлийн хүмүүст ямар нэгэн байдлаар тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох. Үүнд энэ хуульд хамруулах боломж бий юү гэдэг зүйлийг асууя. Мааш олон эмэгтэйчүүд цэргийн алба хааж байгаа цэрэг дайчдаа эрчүүдээ дагаад явдаг.

Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж байгаа хилчин эмэгтэйчүүдийн уулзалтын үеэр ч гэсэн бас эмэгтэйчүүдийн бүлгээ төлөөлж очиж уулзахад эмэгтэй хилийн алба хааж байгаа дайчдын эхнэрүүд гэр бүлийн улсууд яг л энэ асуудлыг тавьж байсан. Бид эр нөхрөө дагаж ёстой нөгөө хайраа дагаж амьдарсаар байтал ингээд тэтгэвэрт гарах насандаа бид нар юү ч үгүй өнгөрдөг өө. Энэ асуудлыг ямар нэгэн байдлаар хуулиар зохицуулж өгөөч гэдэг зүйлийг хүссэн.

Гэтэл тухайн мэргэжлээс шалтгаалан тэтгэвэр тогтоох ямар нэгэн боломж байхгүй гэдэг тайлбарыг л хэлээд байсан л даа. Яг энэ хууль дээр ямар нэгэн байдлаар энэ зохицуулалтыг оруулж болох уу үгүй юү? Нэг ийм санал байна.

П.Анужин: Жаргалмаа гишүүний асуусан асуулт бол саяын Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын

зөрүүтэй саналтай огт холбоогүй зүйл байна.

Гишүүд бас дэгээ барихыг хүсэж байна. Сая бол ямар асуулт асуух байсан бэ гэхээр яг Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан тодорхой санал дээр асуулт асуух байсан.

Жаргалмаа гишүүний асуултад хариулахад та бид баталсан хаврын чуулганаар Нийгмийн даатгалын багц хууль. Уг багц хуульд яг таны асуусан асуултыг маш тодорхой оруулчихсан байгаа. Бид нар энэ гэр бүлийг ажиллах нөхцөлөөр хангах буюу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нийгмийн даатгалынх нь шимтгэлийг төлөх тухай зохицуулалтыг бүр маш тодорхой хуульдаа оруулсан байгаа тийм үү? Манай нийгмийн даатгалын газрынхан ийм зохицуулалт орсон байгаа гэдгийг та мэдэж байгаа байх гэж бодож байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний асуусан асуулттай холбоотойгоор яг энэ асуулттай, зарчмын зөрүүтэй саналтай холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Сандаг-Очир гишүүн сая оруулсан зарчмын зөрүүтэй саналтай холбоотой асуулт байна уу?

Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Энэ хуулийн хэрэгжилт маань хэзээнээс гэж байгаа юм, нэгд.

Хоёрт төсөв хэлэлцэгдэж байна. Энэ хууль батлагдсанаар төсөв дээр ямар эдийн засгийн хувьд ачаалал ирэх үү, энэ хууль батлагдсанаар хэчнээн хүний энэ асуудлуудыг энэ хүрээнд ярих бололцоо боломж үүсэж байгаа юм.

Дагаад үүсэж байгаа төсөв зардлыг ирэх жилийн төсөв төлөвлөгөөнд сууж яваа юу, яваагүй байгаа юу гэдэг ийм асуудлуудыг асууя.

П.Анужин: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын

зөрүүтэй саналтай шууд холбоогүй. Хууль хэзээнээс хэрэгжиж эхлэх вэ гэдэг бол та бидний гар дээр тараасан байгаа 6 дугаар зүйл дээр маш тодорхой бичсэн байгаа.

Бид нар 2024 оны 1 дүгээр сарын 1-нээс гэсэн байгаа тэ. Үлдсэн асуудал дээр бид нар хэлэлцэх эсэх дээр бол маш тодорхой ярилцсан. Тэгэхдээ Оюунчимэг гишүүн нэмэлт хариулт өгье гэж байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

М.Оюунчимэг: Анх энэ хуулийн нэмэлт, өөрчлөлт орж ирж байхад яг санхүүжилттэй холбоотой зөрчил маргаан үүсэх үү гэхэд энэ чинь өөрөө нөгөө төсөв өргөн барихаас өмнө угаасаа бид нар оруулаад ирчихсэн асуудал. Тэгээд Сангийн яамтайгаа яриад санхүүжилт нь 2024 оных дээр тусчихсан. Ямар ч нэмэлт дахиад үүсэх энэ тэр асуудал байхгүй. Энэ дээр зүгээр жирэмсний болон амаржсаны гэдэг нэмэлт, өөрчлөлт нь орж байгаа.

Хэрэгжих хугацаа нь 2024 оны 1 сарын 1-нээс гэж байгаа.

Нэмэлт хариулт байвал манай сайд энэ тэр хариулчхаж болно оо.

П.Анужин: 3 номерын микрофонд гүйцээгээд хариулъя.

Г.Сайханбаяр: Байнгын хорооны дарга, гишүүдийнхээ энэ өглөөний амрыг эрье.

Сандаг-Очир гишүүний асуултад бас тодотгол хийе.

Ер нь бол бид нар энийг ерөөсөө огт шийдвэрлээгүй явж ирсэн асуудал биш. Өмнөх Байнгын хорооны хэлэлцэх эсэх дээр саналаа бид нар бас ярьж байсан.

Бид нар бол энэ цэргийн алба хаагчтай холбоотой асуудал учраас цэргийн цолны мөнгийг нь олгох замаар энэ нийгмийн даатгалын асуудлыг нь нэг талаар шийдэж явж ирсэн асуудал. Тийм

учраас өмнө нь бол энэнтэй холбоотой зардал мөнгөнүүд бас байгууллага байгууллага бүрийн төсөвт сууж явж ирсэн. Одоо 2024 оноос хэрэгжих асуудал дээр бол бид бүх байгууллага дээр жил болгон дунджаар жирэмсний болон амаржсаны чөлөө авдаг эмэгтэйчүүдийн жишигээр төсөвт суулгачихсан байж байгаа.

Тэгэхээр энэ дээр бол ямар нэгэн асуудал байхгүй.

П.Анужин: Хариултыг хангалттай гэж үзэж байна.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулъя гишүүдээ.

Санал хураалт.

90 хувиар уг зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой, байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг саналыг мөн Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн гаргасан байна.

Хоёр дугаар зүйлтэй холбогдуулж Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн зарчмын зөрүүтэй нэг санал гаргасан байна.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэж оруулж ирсэн байна.

Саналтай гишүүд байна уу? Өөр саналтай гишүүд байхгүй байна.

Санал хураалт. Гишүүд санал хураалт явуулъя.

90 хувиар уг зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна

уу? Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух гишүүд байхгүй байна.

Саналтай гишүүд байна уу? Санал хэлэх гишүүн байхгүй байна.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна. Саналтай гишүүн байхгүй байна.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Саналтай гишүүн байхгүй байна.

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Зарчмын зөрүүтэй нэг санал гаргасан Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн. Та бүхэнд танилцуулъя.

Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэж оруулж ирсэн. Саналтай гишүүд байна уу? Байхгүй байна.

Санал хураалт явуулъя гишүүдээ.

6 дугаар зүйлийг танилцуулъя. Энэ хуулийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн зарчмын зөрүүтэй саналыг оруулж ирсэн.

Санал хураалт.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал 90 хувиар дэмжигдлээ.

Уг хуулийн төсөл ер нь их сайн боловсруулагдаж орж ирсэн манай ажлын хэсэг зарчмын зөрүүтэй саналуудыг ч гэсэн бас их нямбай гаргаж оруулж ирсэн учраас хууль маань бас ойлгомжтой сайн дэмжигдлээ.

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал үүгээр өндөрлөсөн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаандаа

идэвхтэй оролцсон эрхэм гишүүд та бүхэндээ баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

10.23 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА*